УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

2018 оны 06 сарын 05 өдөр Дугаар А/144 Улаанбаатар хот

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд нэмэлт
өөрчлөлт оруулах тухай

"Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай" хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 18 дугаар зүйлийн 18.3, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээллэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголын Худалдаачдын холбооны саналыг харгалзан үзэж, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2018 оны А/20 дугаар тушаалаар байгуулагдсан "Нийслэлийн худалдаа, үйлчилгээний нийтлэг журам"-ыг шинэчлэн боловсруулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Монголын Худалдаачдын холбооны тэргүүн З.Пунсалдулам, тус холбооны Удирдах зөвлөлийн гишүүн Х.Бат-Ялалт, Түргэн үйлчилгээний цэгээр амь зуугчдын холбооны тэргүүн Н.Батцэцэг нарыг нэмж оруулсугай.

2. "Нийслэлийн худалдаа, үйлчилгээний нийтлэг журам"-ын шинэчлэн боловсруулсан төслийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хуралд 2018 оны 06 дугаар сард багтаан хэлэлцүүлэхийг Ажлын хэсэг /А.Даваажаргал/-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Т.ГАНТӨМӨР

D:\backup_old_pc\Work documents\doc 2018\Тушаал doc 2018.docx

111339493